

“СҮҮ” ХК-ИЙН ТУЗ-ИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2022 оны 02-р сарын 22-ны өдөр

№ 05

Улаанбаатар хот

ХАЛААСНЫ ХУВЬЦААГ ДАХИЖ ГАРГАЖ, АЖИЛТНУУДАД ХУВЬЦАА ЭЗЭМШҮҮЛЭХ ТУХАЙ

Компанийн тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.8 дахь хэсэг, 76 дугаар зүйлийн 76.1.4 дэх заалт, 80 дугаар зүйлийн 80.2 дахь хэсэг, “Сүү” ХК-ийн дүрмийн 8 дугаар бүлгийн 8.13 дахь хэсэг болон 2022 оны 02 сарын 22-ны өдрийн “Сүү” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Компанийн “Сүү Хувьцаат Компанийн ажилтнуудыг хувьцаагаар урамшуулах хөтөлбөр”-ийн хүрээнд Компанийн халаасны хувьцаанаас нийт 125,000 /Нэг зуун хорин таван мянга/ ширхэг хүртэлх энгийн хувьцааг дахин гаргаж, Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв ХХК-иар дамжуулан ажилтнуудад 2022 оны 4 дүгээр сарын 01-ний өдрийн дотор эзэмшүүлсүгэй.

2. “Сүү Хувьцаат Компанийн ажилтнуудыг хувьцаагаар урамшуулах хөтөлбөр”-ийг энэхүү тогтоолын Хавсралт 1-ийн дагуу баталсугай.

3. “Сүү Хувьцаат Компанийн ажилтнуудыг хувьцаагаар урамшуулах хөтөлбөр”-д заасан болзол, шалгуур хангасан ажилтнуудийн жагсаалт, тус бүрд олгох хувьцааны хэмжээг Хавсралт 2-ийн дагуу баталсугай.

4. Хувьцааны үнийг арилжааны сүүлийн 52 долоо хоногийн дундаж ханшаар тооцохыг Гүйцэтгэх захирал /М.Болод/-д зөвшөөрсүгэй.

5. Энэхүү тогтоол батлагдсантай холбогдуулан Санхүүгийн зохицуулах хороо, Монголын хөрөнгийн бирж ТӨХК, Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв ХХК зэрэг холбогдох эрх бүхий байгууллагуудад мэдээллийг хүргүүлж, халаасны хувьцааг дахин гаргахтай холбоотой мэдээллийг хууль тогтоомжид заасны дагуу нийтэд мэдээлж ажиллахыг Гүйцэтгэх захирал /М.Болод/-д даалгасугай.

6. Энэхүү тогтоолын дагуу Компанийн халаасны хувьцаанаас олгосон энгийн хувьцааг хасч, компанийн санхүүгийн данс бүртгэлд тусгахыг Гүйцэтгэх захирал /М.Болод/-д болон Санхүүгийн алба /Э.Уянга/-нд даалгасугай.

7. Энэхүү тогтоол хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2021 оны 7 дугаар сарын 16-ны өдрийн №16-1 тоот “Ажилтнуудад урамшуулалт олгох тухай” тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

8. Энэхүү тогтоолын дагуу холбогдох ажлыг зохион байгуулах, түүнтэй холбогдох баримт бичигт компанийг төлөөлөн гарын үсэг зурах, төлбөр тооцоог хийхийг Санхүүгийн албаны дарга /Э.Уянга/-д, Гүйцэтгэх захирал /М.Болод/-д тус тус зөвшөөрсүгэй.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Д.ГАНБААТАР